



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/105

Мөрөн

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "е", Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг дарга, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан "2015-2016 оны Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээр"-ын дагуу зохион байгуулагдах "Хөдөлмөрийн хяналт-нийгмийн түншлэл" сургалтын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд зарцуулах 2,788,400 /Хоёр сая долоон зуун наян найман мянга дөрвөн зуу/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт даалгасугай.

3. Энэхүү сургалтын үйл ажиллагааг зохион байгуулалтын өндөр түвшинд хангаж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга /Ж.Ганболд/, Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга /Ц. Ганболд/, Ажил олгогч эздийн холбооны тэргүүн /Л.Төмөрбаатар/ нарт даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

Аймгийн Засаг даргын 2015 оны
03 дугаар сарын 30-ны өдрийн
А/105 тоот захирамжийн хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТ-НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ СЭДЭВТ
СУРГАЛТЫН ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Нэг бүрийн үнэ | Тоо хэмжээ | Бүгд үнэ |
|---|--------------------------------|-----------------|------------|-----------|
| 1 | Оролцогчдын өдрийн хоол | 12000 | 160 | 1,920,000 |
| 2 | Багшийн замын зардал | 1940 | 160 литр | 310,400 |
| 3 | Багшийн байрлах буудлын зардал | 50,000 | 3хоног | 150,000 |
| 4 | Багшийн хоолны зардал | 8000 | 6 удаа | 48,000 |
| 5 | Багшийн хичээл заалтын хөлс | 60,000 | 6 цаг | 360,000 |
| | | Бүгд -2,788,400 | | |